

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**



2019



**ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ГЭМТ ХЭРГИЙН ТАНИЛЦУУЛГА**

ХЯНАСАН:

Д.Мөнхзул

ЧД-ын Статистикийн хэлтсийн дарга

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

М.Батхишиг

ЧД-ын Статистикийн хэлтсийн
ахлах мэргэжилтэн

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, САМБУУГИЙН ГУДАМЖ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БАЙР
401 тоот

Утас: 976- 70113013

976- 70110767

976- 70130767

976-11-310767

Цахим хуудас: www.ubstat.mn
www.chingeltei.gov.mn

Фэйсбүүк хаяг: [chingelteistatistic](https://www.facebook.com/chingelteistatistic)И-мэйл: chingeltei@nso.mn



ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Дүүргийн Онцгой байдлын хэлтэс нь 2019 онд Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр дээр гарсан 690 гал түймрийн дуудлага хүлээн авсан нь өмнөх оноос 173 (20.0%)-аар буурсан байна. Зарцуулсан хөрөнгө өмнөх оноос 58.5 хувиар буурсан бол хамгаалсан хөрөнгө 52.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Гал түймрийн дуудлага, зарцуулсан хөрөнгийн үзүүлэлт, оноор

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2019 2018
Дуудлагын тоо	Тоо	796	670	863	690	-20.0%
Гал түймэр	Тоо	486	471	651	527	-19.0%
Иргэд унтраасан гал түймэр	Тоо	246	169	175	145	-17.1%
Өөрөө унтарсан гал түймэр	Тоо	36	20	25	12	-52.0%
Худал дуудлага	Тоо	28	10	12	11	-8.3%
Ашиглагдсан ус	Тонн	550	743.8	879.5	881.3	0.2%
Ашиглагдсан шатахуун	Литр	23 800.0	26 531.1	26 751.1	12 553.1	-53.1%
Зарцуулсан, мөнгө	Сая.төг	41.2	43.9	66.1	27.4	-58.5%
Аварсан хүний тоо	Тоо	523	567	288	220	-23.6%
Унтраасан барилга байшингийн тоо	Тоо	250	208	225	277	23.1%
Нийт өмч хөрөнгө	Сая.төг	10300	3 800	7 130	10 855.7	52.3%



ГЭМТ ХЭРЭГ

Бүртгэгдсэн гэмт хэрэг Монгол Улсын хэмжээнд 31524 болж өмнөх оноос 4696 (13.0%) хэргээр, Нийслэлийн хэмжээнд 5391 (21.0%) Чингэлтэй дүүрэгт 2642 болж өмнөх оноос 134 (4.8%) хэргээр тус тус буурсан байна.

Хүснэгт 2. Монгол Улс, нийслэл, дүүрэгт бүртгэгдсэн гэмт хэрэг, оноор

Захиргаа	2015	2016	2017	2018	2019	Өөрчлөлт	2019/2018
Улсын дүн	27 757	27 167	32 259	36 220	31 524	-4 696	-13.0%
Нийслэлийн дүн	17 939	17 909	21 947	25 652	20 261	-5 391	-21.0%
Чингэлтэй	2 254	2 337	2 719	2 776	2 642	-134	-4.8%
Багануур	311	293	254	253	167	-86	-34.0%
Багахангай	21	23	31	24	14	-10	-41.7%
Баянгол	2 951	3 137	3 204	4 501	2 834	-1 667	-37.0%
Баянзүрх	4 272	4 218	5 939	7 522	5 465	-2 057	-27.3%
Налайх	423	489	393	420	331	-89	-21.2%
Сонгинохайрхан	3 232	2 962	3 691	3 692	3 470	-222	-6.0%
Сүхбаатар	3 085	2 811	3 816	4 132	3 283	-849	-20.5%
Хан-Уул	1 390	1 639	1 900	2 332	2 055	-277	-11.9%

Нийслэлийн хэмжээнд гэмт хэргийн гаралт 21.0 хувиар буурахад Баянгол дүүрэг 37.0 хувиар, Баянзүрх дүүрэг 27.3 хувиар, Сүхбаатар дүүрэг 20.5 хувиар, Хан-Уул дүүрэг 11.9 хувиар, Сонгинохайрхан дүүрэг 6.0 хувиар, Чингэлтэй дүүрэг 4.8 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 1. Чингэлтэй дүүргийн гэмт хэрэг, улс, нийслэлийн дүнд эзлэх хувиар




Монгол Улсын нийт гэмт хэргийн дүнд Чингэлтэй дүүргийн эзлэх жин 2012 онд 8.2 хувь байсан бол 2019 онд 8.4 хувь болж 0.2 пунктээр өсч, нийслэл хотын дүнд эзлэх хувь 13.9 хувь байсан бол 13.0 хувь болж 0.9 пунктээр буурсан байна. Энэхүү

бууралт нь гэмт хэргийн гаралтанд нөлөөлөх хүчин зүйлс буурч, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлсэн Цагдаагийн бие бүрэлдэхүүний хүчин чармайлтыг илтгэж байна.

Дүүргийн гэмт хэргийн өсөлтийн хувь 2019 онд улсын дүнгээс 8.2 пунктээр, нийслэлийн дүнгээс 16.2 пунктээр өндөр байна.

Зураг 2. Гэмт хэргийн өсөлт, оноор



Зурагаас харахад 2013 оноос гэмт хэргийн гаралт буурч байсан боловч 2017 онд өсч, 2018 оноос эргэн буурсан байна (Зураг2). Өмнөх онтой харьцуулахад 2019 онд улс, нийслэл, дүүргийн цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэрэг буурсан хандлагатай байна.

Дүүргийн Цагдаагийн I хэлтэс нь 1-9 дүгээр хороог хариуцан ажилладаг, Цагдаагийн II хэлтэс нь 10-19 дүгээр хорооны нутаг дэвсгэрийг хариуцан ажилладаг болно. Хүснэгтэд гэмт хэргийг төрлөөр нь ангилан, Цагдаагийн I, II хэлтэст бүртгэгдсэн дүнгээр үзүүлэв.

Хүснэгт 3. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хэргийн ангилалаар, оноор


Гэмт хэргийн төрөл	2018			2019		
	Нийт дүн	Цагдаагийн I хэлтэс	Цагдаагийн II хэлтэс	Нийт дүн	Цагдаагийн I хэлтэс	Цагдаагийн II хэлтэс
Нийт гэмт хэрэг	2 776	1 629	1 147	2 642	1 600	1 042
Хүний амьд явахыг эсрэг	38	15	23	37	5	32
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	601	264	337	541	224	317
Гэр бүлийн хүчирхийлэл	5	-	5	6	1	5
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	27	7	20	37	13	24
Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг	10	9	1	6	5	1
Эрүүл мэндийн эсрэг	2	1	1	2	2	-
Хүүхдийн эсрэг	-	-	-	1	-	1
Өмчлөх эрхийн эсрэг	1 926	1 208	718	1 765	1 140	625
Эдийн засгийн	21	20	1	28	27	1
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	29	23	6	41	30	11
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	15	11	4	18	14	4
Авилгын эсрэг	27	26	1	73	73	-
нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	16	12	4	25	19	6
Хүрээлэн байгаа орчны эсрэг	5	1	4	6	3	3
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	6	6	-	12	12	-
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	51	24	27	50	33	17
Цэргийн албаны эсрэг	1	1	-	-	-	-
Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг	1	1	-	-	-	-

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйлийн 2.6-д заасны дагуу гэмт хэргийг ангилалаар нь хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилдаг байсан бол 2017 оны 5 сарын 11-ний өдөр батлагдсан шинэчилсэн найруулгаар гэмт хэргийн ангилалыг ХӨНГӨН, ХҮНД гэсэн 2 ангилалтай байхаар өөрчилсөн байна. Иймд 2018 оноом гэмт хэргийн ангилалд хүндэвтэр болон онц хүнд гэж бүртгэгдсэн хэрэг үүсээгүй болно.

Хүснэгт 4. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хэргийн ангилалаар, оноор

Гэмт хэргийн төрөл		2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Нийт гэмт хэрэг		1 807	2 115	2 393	2 254	2 337	2 719	2 776	2 642
Гэмт хэргийн ангилалаар	Хөнгөн	798	1 018	1 168	1 050	1 103	1 503	2 043	2 053
	Хүндэвтэр	755	868	1 001	1 011	1 078	537	-	-
	Хүнд	204	177	172	142	107	653	733	589
	Онц хүнд	50	52	52	51	49	26	-	-

Зураг 3. Бүртгэгдсэн гэмт хэргийн тархалт, ангилалаар, оноор



Дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн 2019 оны гэмт хэргийн 77.3 хувийг хөнгөн гэмт хэрэг, 22.3 хувийг хүнд гэмт хэрэг эзлэж байна. Энэ нь үйлдэгдэж буй 4 хэрэг тутмын 1 нь хүнд гэмт хэрэг байгааг харуулж байна.



Хүснэгт 5. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хэргийн төрлөөр, оноор

Гэмт хэргийн төрөл	2014	2015	2016	2017	2018	2019	Өөрчлөлт	<u>2019</u> 2018
Нийт гэмт хэрэг	2 393	2 254	2 337	2 719	2 776	2 642	-134	-4.8
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	697	547	563	628	660	578	-82	-12.4
<i>Хүнийг санаатай алах</i>	16	13	14	17	19	21	2	10.5
<i>Бусдын бие махбодид гэмтэл учруулах</i>	663	524	544	586	625	541	-84	-13.4
<i>Бусдыг амиа хорлоход хүргэх</i>	18	10	5	25	16	16	-	-
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	1 095	1 068	1 276	1 659	1 716	1 765	49	2.9
<i>Хулгай</i>	723	722	908	1 167	1 013	888	-125	-12.3
<i>Булаалт</i>	18	14	24	2	-	-	-	-
<i>Дээрэм</i>	66	41	54	113	87	71	-16	-18.4
<i>Залилан</i>	288	291	290	377	616	558	-58	-9.4
<i>Бусад</i>	-	-	-	-	-	241	241	-
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	179	159	125	80	64	32	-32	-50.0
<i>Хүчиндэх</i>	18	13	17	24	21	32	11	52.4
<i>Танхайрах</i>	161	146	108	56	43	-	-43	-
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	116	142	108	62	51	50	-1	-2.0
Бусад гэмт хэрэг	306	338	265	290	285	224	-61	-21.4

Гэмт хэргийн төрлөөр нарийвчлан авч үзвэл хүчингийн гэмт хэрэг хамгийн өндөр буюу 52.4 хувиар, хүнийг санаатай алах гэмт хэрэг 10.5 хувиар тус тус өссөн байна.

Танхайрах гэмт хэрэг, дээрэмдэх гэмт хэрэг 18.4 хувиар, бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг 13.4 хувиар, хулгайлах гэмт хэрэг 12.3 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 6. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хороогоор, гэмт хэргийн төрлөөр

	Гэмт хэргийн төрөл (Эрүүгийн хуулийн зүйлээр)															
	Нийт хэрэг	Хүнийг алах /10.1/	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх /10.4/	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг /11.1-11.7/	Үүнээс Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх /11.7/	Хүчиндэх /12.1/	Хулгайлах /17.1/	Дээрэмдэх /17.2/	Залилан мэхлэх /17.3/	Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах /20.16/	Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших /17.5/	Эдийн засгийн /18.1-18.18/	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/ 20.7/	Авлигын /22.1-22.12/	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг /27.1-27.11/	Бусад
Дүүргийн дүн	2 642	20	16	541	6	32	888	71	558	42	180	28	36	73	50	107
1-р хороо	240			18		1	64	4	83	8	16	5	4	20	5	12
2-р хороо	210			21			61	3	82	10	21	3		2	1	6
3-р хороо	249			22			71	6	101	6	24	3	2		6	8
4-р хороо	232			30			40	1	52	3	13	9	12	49	4	19
5-р хороо	241			31		2	50	10	90	3	22	3	10	1	4	15
6-р хороо	129	1	1	27		3	26	5	34	1	14	1		1	7	8
7-р хороо	158	2		29	1	1	93	6	6		10	3			3	5
8-р хороо	75			23			30	5	6	3	6				1	1
9-р хороо	66	1		23		3	28	2	2		3				2	2
10-р хороо	88	1	3	27			41	2	4		7				1	2
11-р хороо	123	1		34		1	51	5	19		3	1			4	4
12-р хороо	169	4	3	57	1	3	67	3	16	1	6				4	5
13-р хороо	105	1	1	37	2	2	29	9	11	1	6		1		3	4
14-р хороо	77	2	1	21		2	32	1	12		1				1	4
15-р хороо	72	1	3	22		2	21	1	10	2	6		1		1	2
16-р хороо	95	2	1	36		5	32	1	5	3	7		1		2	0
17-р хороо	77		2	19		2	35	2	8	1	3		1			4
18-р хороо	76	2		30		2	23	2	9		7					1
19-р хороо	160	2	1	34	2	3	94	3	8		5		4		1	5

Гэмт хэрэг үйлдэгсэд 2019 онд 1187 болж өмнөх оноос 50 (4.4%) хүнээр өссөн байна. Гэмт хэрэг үйлдсэдийн 17.1 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа ба уг үзүүлэлт өмнөх оноос 2.5 пунктээр өссөн байна.

Хүснэгт 7. Гэмт хэрэг үйлдэгсэд, насны ангилалаар, оноор


Насны ангилал	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Нийт гэмт хэрэг үйлдэгч	1 590	1 756	1 832	1 682	1 875	1 430	1 137	1 187
15 хүртэл	38	30	29	18	26	34	42	30
16-17 нас	87	81	79	52	74	68	48	57
18-24 нас	527	521	484	454	457	359	268	303
25-29 нас	280	359	400	394	384	310	215	222
30-34 нас	224	236	260	265	318	219	213	178
35-39 нас	161	185	209	174	212	132	123	134
40-44 нас	132	150	151	129	169	108	101	97
45-49 нас	63	97	104	76	108	83	55	66
50-54 нас	48	67	69	66	84	57	32	57
55-59 нас	20	21	27	33	29	40	26	29
60-64 нас	7	7	9	14	4	14	7	12
65-69 нас	3	-	7	5	7	2	2	2
70, түүнээс дээш	-	2	4	2	3	4	5	-

Дүүргийн нийт хүн амын 0.7 хувь, эмэгтэйчүүдийн 0.2 хувь нь гэмт хэрэг үйлдсэн байна.


Гэмт хэрэг үйлдсэн иргэдийн ихэнх буюу 44.2 хувь нь 18-29 насны залуус байгаа бол 54.7 хувь нь бүрэн дунд боловсролтой иргэд байна.

Улсын хэмжээнд 2019 онд нийт 708 сурагч гэмт хэрэг үйлдсэн нь өмнөх оноос 192 (37.2%) -аар өссөн байна. 15 хүртэлх насны хүүхдийн гэмт хэрэг үйлдэлт жил ирэх бүр нэмэгдэж байгаа нь өсвөр насны хүүхдүүдэд тавих хараа хяналтыг сайжруулах, мөн гэмт хэрэгт холбогдохгүй байх, болзошгүй эрсдэлээс сэргийлсэн сургалт, мэдээллийг түгээхэд түлхүү анхаарах шаардлагатай байна.

Зураг 4. Гэмт хэрэг үйлдэгсэд насны бүлгээр, хувиар, 2019 он



Зураг 5. Гэмт хэрэг үйлдэгсэд боловсролын түвшинээр, хувиар, 2019 он



Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо 2019 онд 2503 болж өмнөх оноос 130 (4.9%) хүнээр өссөн байна. Хохирсон иргэдийн 49.4 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оноос 1.8 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.


Хүснэгт 8. Гэмт хэргийн улмаар хохирсон иргэдийн тоо, насны бүлгээр, оноор

Насны ангилал	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Нийт	1 760	2 101	2 241	1 966	2 363	2 574	2 633	2 503
7 хүртэл	-	-	-	-	-	11	6	15
8-13 нас	37	58	32	41	43	49	38	35
14-17 нас	78	68	87	52	57	92	80	60
18-24 нас	364	430	405	301	339	349	336	374
25-29 нас	330	383	452	374	444	471	465	334
30-34 нас	269	303	363	309	340	424	438	437
35-39 нас	230	270	270	237	328	310	347	333
40-44 нас	155	179	216	195	276	266	283	269
45-49 нас	116	166	156	164	195	213	225	225
50-54 нас	92	121	109	148	170	166	181	182
55-59 нас	47	61	88	77	92	110	117	128
60-64 нас	17	30	32	27	34	60	60	61
65-69 нас	13	10	18	21	24	28	35	19
70, түүнээс дээш	12	22	13	20	21	25	22	31


Дүүргийн нийт хүн амын 0.8 хувь, эмэгтэйчүүдийн 1.6 хувь нь гэмт хэргийн хохирогч болсон байна.

Нийт хохирогчдын 35.0 хувийг тухайн үед нь хамгаалалтанд авч ажилласан байна. Мөн 7 иргэн өөрийн буруутай үйл ажиллагаанаас болж хохирогч болсон бол 21 хүн архидаг согтуурч байх үедээ хохирсон байна. Энэ нь өмнөх оноос 70 (76.9%)-аар буурсан байна.


Зураг 6. Гэмт хэргийн хохирогч хөдөлмөр эрхлэлтийн байдлаар, хувиар, 2019 он



Зураг 7. Гэмт хэргийн хохирогч насны бүлгээр, хувиар, 2019 он




Зураг 8. Гэмт хэргийн хохирогчын тоо, ураг төрлийн хамаарлаар оноор



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон иргэд 21 болж өмнөх оноос 26 (55.3%)-аар буурсан байна. Гэр бүлийн хүчирхийллийн гол хохирогч эхнэр байх тохиолдол 2019 онд 11 бүртгэгдэж өмнөх оноос 5 (31.3%)-аар, хохирогч хамтран амьдрагч байх тохиолдол 7 бүртгэгдэж өмнөх оноос 15 (68.2%) хүнээр өссөн байна.

Зураг 9. Гэмт хэрэг үйлдэгдсэн газар, хувиар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг төрлөөр авч үзвэл 10 хэрэг тутмын 3 нь гэр, орон сууцанд, 2 нь гудамж талбайд, 1 нь олон нийтийн газар, 1 нь аж ахуй нэгж байгууллагад, 3 нь нийтийн тээвэр, төрийн байгууллага, төрийн бус байгууллага, авто зам гэх мэт бусад газар үйлдэгдэж байна.



Зам тээврийн осол, зөрчил: Дүүргийн Замын цагдаагийн тасгийн бүрэлдэхүүний гудамж, замд хийсэн хяналт шалгалтаар 2019 онд 141085 зөрчил илрүүлснээс нийт 137469 жолоочийг 3.2 тэрбум төгрөгөөр торгож ажилласан байна. Өмнөх оноос илрүүлсэн зөрчил 17430 (14.1%), торгуулсан жолооч 29173 (26.9%), торгуулсан мөнгөний хэмжээ 299.0 (10.3%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 9. Торгуулсан жолоочийн тоо, торгуулийн хэмжээ, жил бүрийн эцэст

Торгууль	2017	2018	2019
Торгуулсан жолоочийн тоо	99 241	108 296	137 469
Торгуулийн нийт хэмжээ /сая төгрөг/	2 701	2 889	3 188
Торгуулийн дундаж хэмжээ /төгрөг/	27 216	26 676	23 190

Хүснэгт 10. Зам тээврийн зөрчил, зөрчлийн хэлбэрээр, жил бүрийн эцэст

Зөрчлийн хэлбэр	2017	2018	2019	өөрчлөлт	<u>2019</u> 2018
НИЙТ ЗӨРЧИЛ	107 107	123 655	141 085	17 430	14.1
Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон	2 473	2 570	2 581	11	0.4
Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, боловч тээврийн хэрэгсэл жолоодсон	318	329	582	253	76.9
Улсын дугаарын хязгаарлалттай өдөр хориглосон бүсээр зорчсон	5 473	-	-	-	-
Бүрэн бүс тээврийн хэрэгсэл жолоодсон	7 158	8 570	8 411	-159	-1.9
Хамгаалах бүс хэрэглээгүй	10 904	9 393	4 627	-4 766	-50.7
Хориглосон нөхцөлөөр зогссон	29 117	32 247	60 720	28 473	88.3
Хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн	3 020	4 349	692	-3 657	-84.1
Эгнээ байраа буруу эзэлсэн	10 021	10 112	6 452	-3 660	-36.2
Бусад зөрчил	38 623	56 085	57 020	935	1.7



Бүртгэгдсэн
зөрчил - **13635**

Нийт зөрчлийн 71.0 хувийг
ердийн журмаар шийдвэрлэж,
208.3 сая төгрөгөөр торгосон.

Бүх гэмт
хэрэг - **2642**

зөрчил
59.1%

гэмт
хэрэг
4.8%

Хохиролын
хэмжээ
35.4%

Гэмт хэрэг үйлдэгсэд:

НИЙТ
1187
/4.4%/

эмэгтэй
203
/22.3%/

хүүхэд
87
/3.3%/

согтуугаар
286
/42.2%/

ГЭМТ ХЭРГИЙН ТӨРӨЛ

Хүний амьд
явах
эрхийн
эсрэг **37**
/2.6%/

Эрүүл
мэндийн
эсрэг **541**
/10.0%/

Бэлгийн
эрх
чөлөөний
эсрэг **37**
/37.0%/

Өмчлөх
эрхийн
эсрэг **1165**
/8.4%/

Бусад
хэрэг **262**
/42.3%/

Согтуугаар
үйлдэгдсэн гэмт
хэрэг 263 болж
өмнөх оноос
1.2 дахин өссөн
байна

Хулгай, залилангийн
хэрэг нийт гэмт хэргийн
55.0%-ийг эзлэж байна

Гэмт хэргийн улмаас
гэмтсэн хүн **610**

Гэмт хэргийн улмаас
нас барсан хүн **38**

Хохирогч:

нийт **2503** 5.2%↓
эмэгтэй **1238** 1.4%↓
хүүхэд **110** 11.2%↓

гэмт хэргийн
27.3% орон гэрт
үйлдэгдсэн

гэмт хэргийн
19.9% гудамж
талбайд үйлдэгдсэн

гэмт хэргийн
12.8% олон нийтийн
газар үйлдэгдсэн

гэмт хэргийн
40.0% бусад
газар